



**Оюу Толгой ХХК**

Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагаа, Байгаль орчин

Тээврийн удирдлагын төлөвлөгөө

Тээврийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-СЗ-ПЛН-0001	Хувилбар: 1.1

**АГУУЛГА**

<b>1. ТАНИЛЦУУЛГА</b> .....	<b>3</b>
1.1 БАРИМТ БИЧГИЙН ДУГААР .....	3
1.2 ЗОРИЛГО.....	3
1.3 ХЭРЭГЛЭЭ.....	3
1.4 ЭХЛЭХ ОГНОО .....	3
1.5 ЭРХ МЭДЭЛ БА УДИРДЛАГА.....	3
<b>2. ХАМРАХ ХҮРЭЭ</b> .....	<b>4</b>
2.1 УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ .....	4
2.2 БУСАД УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ ДАВХЦАХ БАЙДАЛ.....	4
<b>3. ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА</b> .....	<b>5</b>
3.1 УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ГҮЙЦЭТГЭХ ГОЛ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА.....	5
3.2 Гол уялдаа холбоо .....	5
<b>4. ТӨСЛИЙН СТАНДАРТУУД</b> .....	<b>5</b>
4.1 Монгол улсын холбогдох хууль, СТАНДАРТУУД.....	5
4.2 БОННУ ШААРДЛАГУУД .....	7
4.3 МУ-ын ЗАСГИЙН ГАЗРЫН ӨМНӨ ХҮЛЭЭСЭН БУСАД ҮҮРЭГ АМЛАЛТ, ЗГ-ААС ТАВЬЖ БУЙ ШААРДЛАГУУД.....	7
4.4 Олон улсын холбогдох СТАНДАРТ, УДИРДАМЖУУД .....	7
4.5 ОТ болон Рио Тинтогийн холбогдох СТАНДАРТУУД .....	8
4.6 Төслийн холбогдох СТАНДАРТУУДЫН ХУРААНГУЙ.....	8
<b>5. УДИРДЛАГЫН ХЯНАЛТУУД</b> .....	<b>8</b>
<b>6. ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУВААРЬ</b> .....	<b>15</b>
6.1 УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТ ШИНЭЧЛЭЛ .....	15
6.2 ХЭРЭГЖИЛТИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД .....	15
<b>7. МОНИТОРИНГ</b> .....	<b>15</b>
7.1 МОНИТОРИНГИЙН ШААРДЛАГУУДЫН ТОЙМ .....	15
7.2 ГҮЙЦЭТГЭЛИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	15
7.3 МОНИТОРИНГИЙН ГОЛ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД .....	16
<b>8. СУРГАЛТ</b> .....	<b>19</b>
8.1 Тойм.....	19
8.2 ТАНИЛЦУУЛГА СУРГАЛТ.....	19
8.3 Ажил үүрэгт тусгайлан зориулсан СУРГАЛТ .....	19
<b>9. АУДИТ БА ТАЙЛАН</b> .....	<b>19</b>
9.1 Дотоод аудит.....	19
9.2 Гадаад аудит.....	20
9.3 Бүртгэл хөтлөлт .....	20
<b>10. БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТ</b> .....	<b>20</b>
<b>ХҮСНЭГТҮҮД</b>	
Хүснэгт 1: Гол үүрэг, хариуцлага.....	5
Хүснэгт 2: Төслийн СТАНДАРТУУД.....	8
Хүснэгт 3: Удирдлагын ГОЛ хяналтууд.....	9
Хүснэгт 4: Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд, МОНИТОРИНГИЙН АРГА ХЭМЖЭЭ – ТЭЭВРИЙН МЕНЕЖМЕНТ .....	16
Хүснэгт 5: МОНИТОРИНГИЙН ГОЛ АРГА ХЭМЖЭЭНҮҮД .....	17

Тээврийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-С3-PLN-0001	Хувилбар: 1.1

## 1. ТАНИЛЦУУЛГА

### 1.1 Баримт бичгийн дугаар

Энэхүү баримт бичиг бол Оюу Толгой (ОТ) төсөлд зориулагдсан Тээврийн удирдлагын төлөвлөгөө юм. Уг удирдлагын төлөвлөгөөний баримт бичгийн лавлах дугаар бол ОТ-10-С3-PLN-0001.

### 1.2 Зорилго

Энэхүү удирдлагын төлөвлөгөөний зорилго нь:

- Удирдлагын төлөвлөгөөний хамрах хүрээг тодорхойлж, удирдлагын гол уялдаа холбоог тогтоох;
- Үүрэг хариуцлагыг тодорхойлох;
- Энэхүү удирдлагын төлөвлөгөөтэй холбоотой төслийн стандартуудыг боловсруулах
- Энэхүү удирдлагын төлөвлөгөөтэй холбоотой төслийн үүрэг амлалт, үйл ажиллагааны журам, удирдамжуудыг тодорхойлох
- Мониторинг хийх, тайлагнах журам, тэр дундаа гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүдийг тодорхойлох
- Сургалтын шаардлагуудыг тодорхойлох
- Нэмэлт материал, мэдээллийг эх сурвалжийг тодорхойлох

### 1.3 Хэрэглээ

Энэхүү удирдлагын төлөвлөгөөнд тодорхойлсон шаардлагууд ОТ-ийн бүх үйл ажиллагаа, тэр дундаа гэрээт гүйцэтгэгчид хамаарна.

Энэхүү удирдлагын төлөвлөгөө нь 2008 оны 12 дугаар сард Рио Тинтогоос батлагдан гарсан “С3 Тээврийн хэрэгсэл, түүнийг жолоодох стандарт”-д үндэслэгдсэн болно. Рио Тинтогийн “С3 Тээврийн хэрэгсэл, түүнийг жолоодох стандарт”-д ямар нэг өөрчлөлт орох тохиолдолд тухайн өөрчлөлтийн дагуу ОТ-ийн энэхүү удирдлагын төлөвлөгөө өөрчлөгдөх болно.

Энэхүү удирдлагын төлөвлөгөөний эзэмшигч нь ОТ-ийн Бизнесийн бэлэн байдлыг хангах асуудлыг хариуцсан дэд ерөнхийлөгч болно. Төслийн төлөвлөлт эсвэл журамд орсон өөрчлөлтийг тусгах үүднээс илүү ойр ойрхон хянаж үзэх шаардлагатай болохоос бусад тохиолдолд энэхүү удирдлагын төлөвлөгөөг хоёр жилд нэг удаа хянаж үзээд өөрчлөлт, шинэчлэлт хийх шаардлагатай эсэхийг тогтооно.

### 1.4 Эхлэх огноо

Энэхүү удирдлагын төлөвлөгөө нь 2013 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлнэ.

### 1.5 Эрх мэдэл ба удирдлага

ОТ Гүйцэтгэх хороо энэхүү удирдлагын төлөвлөгөөг 2013 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр баталсан болно. ОТ-ийн Бизнесийн бэлэн байдлын асуудлаг хариуцсан дэд ерөнхийлөгч энэ удирдлагын төлөвлөгөөг хариуцан хадгалах болно. Тус удирдлагын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай аливаа хүсэлтийг энэ хүнд хандаж гаргах ёстой. Хүсэлтийг авч үзэхдээ Өөрчлөлтийн удирдлагын журамд заасанчлан зохих байдлаар хянаж, батлах үйл явцыг дамжих нөхцөл тавигдана.

<b>Тээврийн удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-С3-ПЛН-0001	Хувилбар: 1.1

## 2. ХАМРАХ ХҮРЭЭ

### 2.1 Удирдлагын төлөвлөгөөний хамрах хүрээ

Энэхүү удирдлагын төлөвлөгөө нь өөрөөр заагаагүй бол ОТ-ийн бүх үйл ажиллагаа, тэр дундаа гэрээт гүйцэтгэгчдийн үйл ажиллагааг хамарна. Гэрээт гүйцэтгэгчдийн хэрэгжилттэй холбоотой асуудлыг Гэрээт гүйцэтгэгчийн удирдлагын хүрээнд (ОТ-07-ПЛН-0001) зохицуулсан болно.

Нислэгийн аюулгүй байдлын асуудлыг С7 Нислэгийн аюулгүй байдлын стандартын хүрээнд зохицуулсан бөгөөд уг асуудал нь энэхүү удирдлагын төлөвлөгөөний хүрээнд багтахгүй.

### 2.2 Бусад удирдлагын төлөвлөгөөтэй давхцах байдал

Энэхүү удирдлагын төлөвлөгөө нь Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (БОНМТ)-ний хүрээнд (ОТ-10-ПЛН-0003) тодорхойлсончлон ОТ төсөлд зориулж боловсруулсан “Үйл ажиллагааны удирдлагын иж бүрэн төлөвлөгөө”-ний нэг хэсэг юм.

Энэхүү удирдлагын төлөвлөгөө нь эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, нутгийн ард иргэдэд үзүүлэх төслийн нөлөөллийн асуудлыг хөндсөн удирдлагын хэд хэдэн төлөвлөгөөтэй давхцаж, хөндлөн холбогдож байгаа болно. Эдгээрт:

- Агаар мандалд хорт хий ялгаруулалтын менежментийн төлөвлөгөө (ОТ-10-Е2-ПЛН-0001), ялангуяа уурхайн талбайгаас гадуур байх үед нисэх буудлын үйл ажиллагаанаас үүдэлтэй дуу чимээнд өртөх явдлыг удирдахтай холбоотой хэсэг;
- Аюултай бодисын менежментийн төлөвлөгөө (ОТ-10-Е5-ПЛН-0001), ялангуяа нутгийн ард иргэд болон байгаль орчныг аюултай бодис, асгаралтанд өртүүлэхээс хамгаалахтай холбоотой хэсэг;
- Онцгой байдлын үеийн бэлэн байдал ба хариу арга хэмжээний төлөвлөгөө (ОТ-12-ПЛН-0011), ялангуяа уурхайн талбайгаас гадуур аваар, осол, онцгой байдлын үед тээвэрлэлт хийхтэй холбоотой хэсэг
- Нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, хамгаалалтын төлөвлөгөө (ОТ-10-ПЛН-0001), ялангуяа нутгийн ард иргэд төслийн талбайн гадна талд тээвэрлэлттэй холбоотой төслийн эрсдлүүдэд өртөх явдалтай холбоотой хэсэг
- Аюулгүй байдлын төлөвлөгөө (2012), ялангуяа харуул, хамгаалалтын ажилтнуудын удирдлага, зан байдалтай холбоотой хэсэг
- Биологийн төрөл зүйлийн менежментийн төлөвлөгөө (ОТ-10-Е9-ПЛН-1001), ялангуяа замын аюулгүй байдал болон ан амьтантай холбоотой хэсэг

<b>Тээврийн удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-С3-PLN-0001	Хувилбар: 1.1

### 3. ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

#### 3.1 Удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гүйцэтгэх гол үүрэг, хариуцлага

Уг төлөвлөгөөний хэрэгжилтэнд гүйцэтгэх гол үүрэг, хариуцлагыг дор харуулав.

##### Хүснэгт 1: Гол үүрэг, хариуцлага

Үүрэг	Хариуцлага
ОТ Үйл ажиллагаа хариуцсан захирал	<ul style="list-style-type: none"><li>Тус төсөл нь уг төлөвлөгөөнд тодорхойлсон төслийн стандартууд болон бусад стандартыг хангах асуудлыг хариуцна</li></ul>
ОТ Бизнесийн бэлэн байдлыг хангах асуудлыг хариуцсан дэд ерөнхийлөгч	<ul style="list-style-type: none"><li>Төлөвлөгөөний хамрах хүрээ болон хэрэгжилтийн асуудлыг ерөнхийд нь хариуцах</li></ul>
Тээврийн гэрээт гүйцэтгэгдчийн менежерүүд (үйл ажиллагаа, барилга угсралтад хамааралтай)	<ul style="list-style-type: none"><li>Гэрээт гүйцэтгэгчид ОТ шаардлагыг хангаж байгаа явдлыг баталгаажуулах</li></ul>

#### 3.2 Гол уялдаа холбоо

Энэхүү удирдлагын төлөвлөгөөний хэрэгжилтийн гол интерфэйсүүд (ө.х. уг удирдлагын төлөвлөгөөний элементүүдийг ханган нийлүүлэх хариуцлага бүхий үүргүүд) нь:

- Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны асуудал хариуцсан ерөнхий менежер, ялангуяа байгаль орчны асуудал, уурхайн талбайгаас гадуурх аюулгүй ажиллагааны чиглэлээрх үйл ажиллагаа хариуцсан менежер
- Тээврийн гэрээт гүйцэтгэгчдийг хариуцсан гэрээний менежерүүд (үйл ажиллагаа болон барилга угсралтын)
- СЗ Гүйцэтгэх, хадгалах баг.

### 4. ТӨСЛИЙН СТАНДАРТУУД

Төслийн бүх үйл ажиллагаанд холбогдох стандартуудыг дагаж мөрдөх ёстой ("Төслийн стандартууд"). Төслийн стандарт нь дараахь хэсгүүдээс бүрдэнэ.

- Монгол улсын холбогдох хууль, стандартууд;
- БОННУ-ийн шаардлагууд;
- Монгол улсын Засгийн газрын холбогдох эрх бүхий байгууллагуудын өмнө хүлээсэн бусад үүрэг, амлалт, ЗГ-аас тавьж буй шаардлагууд;
- Холбогдох зээлдүүлэгчийн стандарт, удирдамжууд;
- Рио Тинтогийн холбогдох стандартууд
- ОТ-ийн зүгээс тууштай дагаж мөрдөж буй уул уурхайн салбарын бусад удирдамжууд.

#### 4.1 Монгол улсын холбогдох хууль, стандартууд

Тээврийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-СЗ-ПЛН-0001	Хувилбар: 1.1

### Монгол улсын хуулиуд

*Автотээврийн тухай хууль (1999 оны 6 дугаар сарын 15-нд батлагдан гарч, 2011 онд нэмэлт, өөрчлөлт орсон).* Уг хуулинд автотээврийн хэрэгслээр ачаа болон зорчигч тээвэрлэх үйл ажиллагаанд тавигдах ерөнхий нөхцөл, шаардлага, мөн автотээврийн хэрэгсэлд тавигдах техникийн шаардлагын хууль эрх зүйн үндэслэлийг тодорхойлж өгсөн болно.

*Авто замын тухай хууль (1998 оны 6 дугаар сарын 20-нд батлагдан гарч, 2009 онд нэмэлт, өөрчлөлт орсон).* Энэ хуулийн зорилт нь авто зам, замын байгууламжийг барих, засварлах, арчлах, санхүүжүүлэх, ашиглах, хянахад оршино. Монгол улсад авто замыг дараахь байдлаар ангилдаг.

- олон улсын чанартай авто зам;
- улсын чанартай авто зам;
- орон нутгийн чанартай авто зам;
- аж ахуйн нэгж, байгууллагын дотоодын авто зам.

Монгол улсын Засгийн газраас (МУЗГ) улсын болон олон улсын чанартай авто зам барих, засварлах, арчлах зориулалт бүхий Улсын авто замын санг ажиллуулдаг. Аймаг, сумд тус бүртээ өөрийн гэсэн авто замын сантай бөгөөд орон нутгийн чанартай авто зам барих, засварлах, арчлахад зарцуулагдах зориулалттай болно. Ийм орон нутгийн авто замын сан нь аймгийн Засаг даргын мэдэлд байдаг. Авто замын санд хувийн хэвшлийн байгууллагуудаас хандив, санхүүгийн дэмжлэг хүлээн авч болно.

Зам барих, арчлах лицензийг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамнаас олгодог.

Дээрх хуулиас гадна Барилгын тухай хуулинд зам барих үйл ажиллагаанд хамааралтай шаардлагууд тодорхойлогдсон байдаг. МУЗГ болон хяналт, шалгалтын агентлагуудын замтай холбоотой үйл ажиллагааг удирдах, хянах, зохицуулах эрх мэдлийн талаар Авто замын тухай хуулинд мөд адил авч үзсэн байгаа.

Бусад холбогдох хууль, тогтоомжид:

- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль (1996 оны 4 дүгээр сарын 30-нд батлагдан гарч, хамгийн сүүлд 2011 онд өөрчлөгдсөн). Уг хуулинд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах журмууд, тэр дундаа авто зам төлөвлөх, барих, өргөтгөх, засварлах чиглэлээрх замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах арга хэмжээнүүдийн талаарх заалтууд багтсан байгаа.
- Жолоочийн даатгалын тухай хууль (2011 оны 10 дугаар сарын 6-нд батлагдан гарсан). Энэ хуулийн зорилт нь жолоочийг хариуцлагын албан журмын даатгалд хамруулах, зам, тээврийн ослын улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хохирогчийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- Монгол Улсын Засгийн газраас 2004 онд гаргасан “Замын хөдөлгөөний дүрмийн” талаарх 74 дүгээр тогтоол (2004 онд хэрэгжиж эхэлсэн). Энэ дүрмийн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний нэгдсэн журам тогтооход оршино. Уг дүрэмд тээврийн хэрэгслийн төрөл, жолооч болон явган зорчигчийн эрх, үүрэг, замын тэмдгүүдэд тавигдах нөхцөл, шаардлагууд зэрэг асуудлууд багтсан болно.
- Дэд бүтцийн хөгжлийн сайдын 2001 оны 75 дугаар тушаалаар батлагдсан “Нисэхийн хөдөлгөөн – Иргэний нисэхийн багц дүрэм”
- Дэд бүтцийн хөгжлийн сайдын 2000 оны 119 дугаар тушаалаар батлагдсан “Автотээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журам”

Тээврийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-СЗ-ПЛН-0001	Хувилбар: 1.1

- Аялал жуулчлал, байгаль орчны сайд, Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2009 оны 28/40/29-р хамтарсан тушаалаар батлагдсан “Химийн хорт ба аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”
- Дэд бүтцийн хөгжлийн сайдын 1998 оны 159 тоот тушаалаар батлагдсан “Иргэний агаарын хөлгөөр тээвэр хийх журам”
- Дэд бүтцийн сайд болон Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд нарын 2001 онд гаргасан 108/115 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Автотээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх журам” зэрэг багтана.

#### Монгол улсын стандартууд

- MNS 5831:2007 – Улс хоорондын автотээврийн ачаа, зорчигч тээвэрлэлтийн ерөнхий шаардлага;
- MNS 4598:2003 – Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага;
- MNS 5345:2003 – Овор ихтэй, урт, хүнд ачааны тээвэрлэлт. Ангилал, Ерөнхий шаардлага;
- Монгол улсын авто тээврийн хэрэгслийн утаа ялгаруулалтын стандартууд: Бензин хөдөлгүүрийн утааны стандарт (MNS 5031:2003) дизель хөдөлгүүрийн стандарт (MNS 5014:2003);
- MNS 5011: 2003 - Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх заавар. Ерөнхий шаардлага;
- MNS 5345:2011 - Овор ихтэй ачааны тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлага;
- MNS 5013:2003 - Бензинээр ажилладаг хөдөлгүүртэй автомашин – Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга
- MNS 5014:2009 - Автомашины дизель хөдөлгүүрийн утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга”.

#### 4.2 БОННУ шаардлагууд

БОННУ болон тээвэрлэлттэй холбоотойгоор ОТ төсөлд шууд оруулсан Байгаль орчны хамгааллын холбогдох төлөвлөгөөнүүдэд тодорхой шаардлага заагдаагүй болно.

#### 4.3 МУ-ын Засгийн газрын өмнө хүлээсэн бусад үүрэг амлалт, ЗГ-аас тавьж буй шаардлагууд

Монгол Улсын төрийн байгууллагуудаас тавьж буй шаардлагыг хангах үүрэг амлалтыг тодорхойлсон гол баримт бичиг бол ОТ төслийн хөрөнгө оруулалтын гэрээ (2009 оны 10 дугаар сарын 6-нд гарын үсэг зурсан) юм. Уг гэрээний “Дэд бүтэц” буюу дөрөвдэх бүлэг:

*“7.11 Улсын болон орон нутгийн чанартай зам, дамжуулах хоолой, тээвэрлэлтийн бусад барилга байгууламж барих үед Хөрөнгө оруулагч нь Монгол улсын хууль тогтоомжийг даган мөрдөж, зам тээврийн нэгдсэн сүлжээ болон хот байгуулалтын стратеги бодлоготой уялдуулах тал дээр хүчин чармайлт гаргах болно гэж заажээ.*

#### 4.4 Олон улсын холбогдох стандарт, удирдамжууд

Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн дараахь нэр бүхий удирдамж, хууль стандартыг анхааралдаа авч үзсэн болно:

- ОУСК Уул уурхайд зориулсан байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдамж (2007 оны 12 дугаар сар), үүнд аюултай бодис, тэр дундаа тэсрэх бодис тээвэрлэхэд тавигдах шаардлагууд багтана

<b>Тээврийн удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-С3-PLN-0001	Хувилбар: 1.1

- ОУСК Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын ерөнхий удирдамж (2007 оны 4-р сар)
- Дэлхийн замын аюулгүй байдлын түншлэлээс боловсруулж гаргасан гарын авлагууд, тэр дундаа замын хөдөлгөөний осол, бэртлээс урьдчилан сэргийлэх чиглэлээрх дараахь гарын авлагууд:
  - Согтууруулах ундаа хэрэглэх ба жолоодох;
  - Суудлын бүс, хүүхдийн хязгаарлагчууд
  - Хурдны менежмент.
- 2002 оны *Зам тээврийн удирдамж 2002/15/EC (Европын зам тээврийн ажлын цагийн удирдамж)*.

#### **4.5 ОТ болон Рио Тинтогийн холбогдох стандартууд**

Рио Тинтогийн холбогдох гол стандартуудад:

- Рио Тинтогийн ЭАБ. Стандарт С3 – Тээврийн хэрэгсэл, түүнийг жолоодох, 2008 оны 12-р сар
  - Замын барилга, арчилгаа, засвар үйлчилгээний журам (ОТ-10-С3-PRC-0001)
  - Хүнд машин механизм ажиллуулах журам (ОТ-10-С3-PRC-0002)
  - Хөнгө тээврийн хэрэгсэл ажиллуулах журам (ОТ-10-С3-PRC-0003)
  - Автомашины дугуй, обудны талаар баримтлах журам (ОТ-10-С3-PRC-0004)
  - ОТ-н ажлын талбайн замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө (ОТ-10-С3-PRC-0005)

#### **4.6 Төслийн холбогдох стандартуудын хураангуй**

ОТ нь улсын стандарт, холбогдох зээлдүүлэгчдийн стандарт болон Рио Тинтогийн холбогдох стандартуудын аль илүү хатуу чанга дүрмийг нь Төслийн стандарт болгож дагаж мөрдөх болно.

Төслийн холбогдох стандартуудыг дор хураангуйлав..

#### **Хүснэгт 2: Төслийн стандартууд**

<b>Стандарт</b>	<b>Хамрах хүрээ</b>
Рио Тинто ЭАБ. Стандарт С3 – Тээврийн хэрэгсэл, түүнийг жолоодох, 2008 оны 12 дугаар сар	<ul style="list-style-type: none"> <li>• Ажлын талбайд болон түүний гадна буй бүх тээврийн хэрэгсэл</li> </ul>

### **5. УДИРДЛАГЫН ХЯНАЛТУУД**

Төслийн БОННУ-ийн тайланд тодорхойлсон эрсдэл, нөлөөллүүдийг удирдах үүднээс “Стандарт С3 – Тээврийн хэрэгсэл, түүнийг жолоодох” стандартын хүрээнд боловсруулсан менежментийн хяналтаас гадна менежментийн хэд хэдэн хяналтыг боловсруулсан. Менежментийн гол хяналтуудыг холбогдох баримт бичгийн нэрийн хамт дор харуулав. Тэдгээр баримт бичгээс хэрэгжилтийн талаарх мэдээллийг авч болно.



Тээврийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-СЗ-ПЛН-0002-М	Хувилбар: 1.1

**Хүснэгт 3: Удирдлагын гол хяналтууд**

ID	Сэдэв/ Хэсэг	Хэрэглэж болох байдал/ Үйл ажиллагаа	Арга хэмжээний тодорхойлолт	Хариуцагч	Нягтлах арга
TMP 01	Замын зураг төсөл	Замын зураг төсөл	Сайжруулсан зам барихдаа үйрмэг, бутарган давхарга эсвэл бусад зохимжтой материал ашиглана. (ОТ-10-СЗ-PRC-0001 баримт бичгээс үзнэ үү).	ОТ Барилга угсралтын хэлтэс	Замын зураг төслийн техникийн үзүүлэлтүүд
TMP 02	Замын зураг төсөл	Замын зураг төсөл	ОТ-с Гашуун Сухайт руу баяжмал экспортлох чиглэлд давхар хучилттай зам барих болно.	ОТ Барилга угсралтын хэлтэс	Замын зураг төслийн техникийн үзүүлэлтүүд
TMP 03	Замын зураг төсөл	Замын зураг төсөл	Замын ус зайлуулах хоолой суурилуулж өгөх бөгөөд энэ хоолой нь 10 жилд 1 удаа үерийн ус зайлуулах хүчин чадалтай байна. Усны ундарга хэсэгт байрлуулсан ус зайлуулах хоолой нь 100 жилд 1 удаа тохиолдох үерийг зайлуулах хүчин чадалтай байна.	ОТ Барилга угсралтын хэлтэс	Замын зураг төслийн техникийн үзүүлэлтүүд
TMP 04	Замын зураг төсөл	Замын зураг төсөл	Эмзэг байршлуудад ОТ-оос Гашуун-Сухайтын чиглэлд, ОТ-с Ханбогд сумын чиглэлд, ОТ-с нисэх буудлын зам руу явж буй машиныг саатуулах боловч ан амьтад зам хөндлөн гарахад саад болохгүй байгууламжуудыг угсарч суурилуулах болно. Мал зам хөндлөн гарахад зориулагдсан хэсгүүдийг нутгийн малчидтай зөвлөлдсөний үндсэн дээр суурилуулах болно (ОТ-10-СЗ-PRC-0001, 4.1.7-р заалтыг үзнэ үү). Эдгээр байгууламжийг суурилуулах хуваарийг БТЗҮАТ-д тодорхойлсон болно.	Барилгын ажлыг - ОТ Барилга угсралтын хэлтэс Ан амьтдын зам хөндлөн гаралтын эцсийн үзүүлэлтийг – ОТ Байгаль орчны хэлтэс	Замын зураг төслийн техникийн үзүүлэлтүүд
TMP 05	Off-Road Driving	Зориулалтын замын ашиглалт	Бүх тээврийн хэрэгсэл одоо байгаа зам, харгүй, тусгайлан тодорхойлсон чиглэлийг ашиглах болно. Зөвхөн онцгой буюу өө сонголтгүй болсон тохиолдолд, жишээлбэл хайгуул,	Машин хэрэглэдэг бүх хүмүүс	Аяллын менежментийн систем

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

### Тээврийн удирдлагын төлөвлөгөө

Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-С3-PLN-0002-М	Хувилбар: 1.1
---	---	------------------

ID	Сэдэв/ Хэсэг	Хэрэглэж болох байдал/ Үйл ажиллагаа	Арга хэмжээний тодорхойлолт	Хариуцагч	Нягтлах арга
			байгаль орчны судалгааны ажлаар, зам байхгүй газар явж байхдаа замгүй газар машин жолоодохыг зөвшөөрнө.		
TMP 06	Замын аюулгүй байдал	Замын тэмдэг	ОТ-ийн байнга ашигладаг замууд дээр мал, ан амьтан зам хөндлөн гарч болзошгүй хэсгүүдэд жолооч нарт анхааруулах тэмдэг байрлуулах болно. Эдгээр замд ОТ-ГС чиглэлийн зам, ОТ-ХБ чиглэлийн зам, мөн Гүний хоолойд хүрэх зам багтана. Түрүүлж явах эрхийг замын уулзвар дээр тодорхой байдлаар зааглаж өгөх болно (ОТ-10-С3-PRC-0005-г үзнэ үү).	ОТ Барилга угсралтын хэлтэс	Тэмдэг байрлуулах
TMP 07	Замын аюулгүй байдал	Жолоочид зориулсан дүрэм	Олон нийттэй харилцах мэргэжилтэн болон амьтан судлаач-мэргэжилтэнтэй (хэрэв шаардлагатай бол) хамтран хийсэн эрсдлийн үнэлгээнд тулгуурлан хурдны тусгай хязгаарлалт тогтоосон хэсгүүдэд буюу эмзэг/өндөр эрсдэл бүхий нутаг дэвсгэр (бааз, малчид, ан амьтад байнга зам хөндлөн гардаг цэгүүд)-т хурдны дээд хязгаарыг 80 км/цаг байхаар тогтооно. Хурдны хязгаарыг ОТ-ийн бүх тээврийн хэрэгсэлд суулгаж өгсөн GPS машин хянах системээр хянах болно. Ийм системийг гэрээт гүйцэтгэгчдийн машин дээр шаардлагатай болон боломжтой үед нь суулгаж өгөх болно (ОТ-10-С3-PRC-0003-г үзнэ үү).	ОТ ЭАБ-ны хэлтэс  ОТ Үйл ажиллагаа, барилгын логистикийн менежерүүд	Бүртгэлийг хянаж үзэх
TMP 08	Ан амьтан	Жолоочид зориулсан дүрэм	ОТ-ийн бүх жолооч мал, ан амьтан, том шувуу, том хөхтөн амьтадтай мөргөлдсөн тухайгаа тухай бүрт нь ОТ-ийн Байгаль орчны хэлтэст мэдэгдэж байх ёстой.	ОТ ЭАБ-ны хэлтэс	ОТ-ийн Байгаль орчны хэлтэст хадгалагдаж буй ан амьтдыг мөргөсөн тохиолдлуудын бүртгэл
TMP 09	Замын аюулгүй	Жолоочид зориулсан	ОТ нь Рио Тинтогийн “С3 Тээврийн хэрэгслүүд, тэдгээрийг	ОТ ЭАБ-ны	Бүртгэлийг

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Тээврийн удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-С3-PLN-0002-М	Хувилбар: 1.1

ID	Сэдэв/ Хэсэг	Хэрэглэж болох байдал/ Үйл ажиллагаа	Арга хэмжээний тодорхойлолт	Хариуцагч	Нягтлах арга
	байдал	дүрэм	жолоодох стандарт-ыг хэрэгжүүлэх болно.	хэлтэс	хянаж үзэх
TMP 10	Замын аюулгүй байдал	Сургалт	Жолоочийн хамрагдах ёстой сургалтын хамгийн наад захын шаардлагыг ОТ-ийн ажлын талбайг хамарсан замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө (ОТ-10-С3-PRC-0005)-нд харуулсан болно.	ОТ ЭАБ-ны хэлтэс	Бүртгэлийг хянаж үзэх
TMP 11	Замын аюулгүй байдал	Лицензжүүлэлт	Рио Тинтогийн “С3 Тээврийн хэрэгслүүд, тэдгээрийг жолоодох стандарт (ОТ-10-С3-STD-0003-Е-С3)”-д заасны дагуу ОТ-ийн бүх жолооч Монгол улсын хүчинтэй жолооны үнэмлэхтэй байх ёстой. Мөн, ОТ-ын заавал хамрагдах ёстой сургалтанд бүрэн хамрагдаж байгууллагын зохих дотоод зөвшөөрлийг авсан байх ёстой.	ОТ ЭАБ-ны хэлтэс	Жолоочийн хамрагдсан сургалтын бүртгэл
TMP 12	Замын аюулгүй байдал	Аяллын менежментийн төлөвлөгөө	Талбайгаас гадуурх тээврийн хэрэгслийн бүх хөдөлгөөн ОТ-ийн Аяллын менежментийн систем (ОТ-10-С3-PRC-0003)-ийн дагуу явагдах болно.	Машин хэрэглэдэг бүх хүмүүс	Бүртгэлийг хянаж үзэх
TMP 13	Замын аюулгүй байдал	Гэрээт гүйцэтгэгчийн менежмент	Рио Тинтогийн “С3 Тээврийн хэрэгслүүд, тэдгээрийг жолоодох стандарт (ОТ-10-С3-STD-0003-Е-С3)”-д заасны дагуу энэхүү Тээврийн удирдлагын төлөвлөгөөнд заасан шаардлагууд нь ОТ-ийн барилга угсралтын талбай, үйл ажиллагааны талбай болон уурхайн лицензийн талбай дотор тээврийн хэрэгсэл жолоодож буй ОТ-ийн гэрээт гүйцэтгэгчдэд хамаарах болно. Нийтийн зам дээр ОТ ажлын талбай руу очихын тулд нэг удаа эсвэл тогтмол бус байдлаар (сард <1 удаа) машин жолооддог гэрээт гүйцэтгэгчид энэ төлөвлөгөөнд хамрахдаг ёстой гэж эрсдлийн үнэлгээнд заагдсан байхаас бусад тохиолдолд тэдгээр гүйцэтгэгчид энэ төлөвлөгөөнд хамрагдахгүй.	ОТ Худалдан авалтын хэлтэс	Бүртгэлийг хянаж үзэх

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

### Тээврийн удирдлагын төлөвлөгөө

Хүчин төгөлдөр  
болох огноо:  
2013.09.01

Баримт бичгийн дугаар:  
ОТ-10-СЗ-ПЛН-0002-М

Хувилбар:  
1.1

ID	Сэдэв/ Хэсэг	Хэрэглэж болох байдал/ Үйл ажиллагаа	Арга хэмжээний тодорхойлолт	Хариуцагч	Нягтлах арга
ТМР 14	Замын аюулгүй байдал	Гэрээт гүйцэтгэгчийн хариу арга хэмжээний төлөвлөгөө	ОТ-ийн гэрээт гүйцэтгэгчид төлслийн талбайн гадна явагдах үйл ажиллагаанд зориулж “Аваарын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөө” боловсруулах болно. Энэ төлөвлөгөө нь ОТ-ийн “Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөө” болон “Гэрээт гүйцэтгэгчдийн менежментийн төлөвлөгөө”-тэй нийцсэн байх ёстой.	ОТ Гэрээт гүйцэтгэгчид	Гэрээт гүйцэтгэгчийн “Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөө”
ТМР 15	Замын аюулгүй байдал	Зам засвар	ОТ-ийн барьсан, мөн засвар арчилгаа хийдэг замуудыг ОТ-ийн Замын барилга, засвар арчилгааны журмын дагуу удирдах болно (ОТ-10-СЗ-PRC-0001-г үзнэ үү).	ОТ Барилга угсралтын хэлтэс	Бүртгэлийг хянаж үзэх
ТМР 16	Замын аюулгүй байдал	Тоос дарах	Хэрэв нутгийн иргэдийн оролцоотой тоос хянах хөтөлбөрийн хүрээнд боломжит бэрхшээлүүдийг тодорхойлсон бол, эсвэл ОТ-ийн Байгаль орчны хэлтсээс хэрэгжүүлэх шаардлагтай гэж үзсэн бол тоосны менежментийн стратегиудыг боловсруулж, эмзэг нутаг дэвсгэрийн (малчны хашаа хороо гэх мэт) ойр орчимд хэрэгжүүлнэ (тэр дундаа Аюултай бодисын менежментийн төлөвлөөнд тодорхойлсончлон химийн бодисын эрсдлийн үнэлгээнд үндэслэн тоос дарагч химийн бодис ашиглах).	ОТ Байгаль орчны хэлтэс	Уурхайн талбайд хамаарах тоосны менежментийн төлөвлөгөө
ТМР 17	Замын аюулгүй байдал	Машины үзлэг	Тээврийн хэрэгсэлд үйлдвэрлэгчээс өгсөн заавар, удирдамж болон Монгол улсын лицензийн шаардлагын дагуу техникийн үйлчилгээ хийж, баталгаажуулах үзлэг шалгалтыг тогтмол явуулах болно.		Машинд хийсэн засвар үйлчилгээний бүртгэл
ТМР 18	Замын аюулгүй байдал	Машины үзлэг	ОТ талбай руу нэвтэрч буй тээврийн хэрэгслүүдийг үзлэгт хамруулж, ан амьтны гаралтай бүтээгдэхүүн гэх мэт хориотой/хууль бус бүтээгдэхүүн тээвэрлэж буй эсэхийг шалгах болно (ОТ-10-СЗ-PRC-0005-г үзнэ үү).	ОТ Хамгаалалтын хэлтэс	Машинд хийсэн техникийн үзлэг

**Тээврийн удирдлагын төлөвлөгөө**

Хүчин төгөлдөр  
болох огноо:  
2013.09.01

Баримт бичгийн дугаар:  
ОТ-10-СЗ-PLN-0002-М

Хувилбар:  
1.1

ID	Сэдэв/ Хэсэг	Хэрэглэж болох байдал/ Үйл ажиллагаа	Арга хэмжээний тодорхойлолт	Хариуцагч	Нягтлах арга
TMP 19	Замын аюулгүй байдал	Асаахын өмнөх үзлэг	ОТ-ийн хөнгөн тээврийн хэрэгсэл ажиллуулах журам (ОТ-10-СЗ-PRC-0003-Е) болон Хүнд машин механизм ажиллуулах журам (ОТ-10-СЗ-PRC-0002)-ын дагуу бүх тээврийн хэрэгсэлд асаалтын өмнөх үзлэг хийнэ.	Машин хэрэглэдэг бүх хүмүүс	Бүртгэлийг хянаж үзэх
TMP 20	Замын аюулгүй байдал	Хэрэг зөрчлийн менежмент	Төслийн талбайд гарсан хэрэг зөрчлийг ОТ-ийн Ажлын талбайд хамарсан замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөөний (ОТ-10-СЗ-PRC-0005) дагуу удирдаж зохицуулах болно.	ОТ ЭАБ-ны хэлтэс	Бүртгэлийг хянаж үзэх
TMP 21	Замын аюулгүй байдал	Хариу арга хэмжээний төлөвлөгөө	Талбайн гадуурх хэрэг зөрчлийг Аваарын үеийн хариу арга хэмжээний төлөвлөгөөний дагуу удирдах болно.	ОТ ЭАБ-ны хэлтэс	Бүртгэлийг хянаж үзэх
TMP 22	Замын аюулгүй байдал	Аюултай бодисын тээвэрлэлт	Аюултай бодисын тээвэрлэлтийг Аюултай бодис, бохирдлыг хянах менежментийн төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэнэ.	ОТ Худалдан авалтын хэлтэс	Бүртгэлийг хянаж үзэх
TMP 23	Замын аюулгүй байдал	Зөвшөөрлүүд	Рио Тинтогийн “СЗ Тээврийн хэрэгслүүд, тэдгээрийг жолоодох стандарт (ОТ-10-СЗ-STD-0003-Е-СЗ)”-д заасны дагуу бүх жолооч жолооны үнэмлэх, зөвшөөрөл авсан байх ёстой.	ОТ Сургалтын баг	Бүртгэлийг хянаж үзэх
TMP 24	Замын аюулгүй байдал	Эрүүл мэндийн хувьд тэнцсэн	Бүх жолооч эрүүл мэндийн хувьд шаардлага хангасан байх ёстой. Ажилтнууд согтууруулах ундаа уусны дараагаар жолоо барих ёсгүй. Үндэсний хэмжээнд болон талбайд мөрдөгддөг цусан дахь алкологийн түвшний хязгаар бол 0.00% ВАС. Жолооч нар тээврийн хэрэгсэл ажиллуулж байхдаа ядраагүй байх ёстой (ОТ-10-СЗ-PRC-0002, ОТ-10-СЗ-PRC-0003, ОТ-10-СЗ-PRC-0005-г үзнэ үү).	Машин хэрэглэдэг бүх хүмүүс	Бүртгэлийг хянаж үзэх
TMP 25	Замын аюулгүй байдал	Зөв тоног төхөөрөмж	Бүх тээврийн хэрэгслийг тодорхойлж, удирдана.	СЗ баг	Бүртгэлийг хянаж үзэх

**ОЮУ ТОЛГОЙ ХХК**
**Тээврийн удирдлагын төлөвлөгөө**

Хүчин төгөлдөр  
болох огноо:  
2013.09.01

Баримт бичгийн дугаар:  
ОТ-10-СЗ-ПЛН-0002-М

Хувилбар:  
1.1

ID	Сэдэв/ Хэсэг	Хэрэглэж болох байдал/ Үйл ажиллагаа	Арга хэмжээний тодорхойлолт	Хариуцагч	Нягтлах арга
TMP 26	Замын аюулгүй байдал	Согтууруулах ундаа, мансууруулах бодис	Зөвшөөрөл олгосон байхаас (жишээлбэл эмнэлэг эсвэл амралт, алжаалын цэг рүү хүргэлт хийх гэх мэт) бусад тохиолдолд согтууруулах ундаа, мансууруулах бодисыг тээврийн хэрэгслээр зөөвөрлөж болохгүй.	Машин хэрэглэдэг бүх хүмүүс	Бүртгэлийг хянаж үзэх
TMP 27	Замын аюулгүй байдал	Согтууруулах ундаа, мансууруулах бодис	Компанийн эзэмшлийн тээврийн хэрэгслийг төслийн талбайд мөн түүнээс гадуур жолоодох үед цусан дахь спиртийн агууламжийг тэг, мөн мансууруулах бодисын түвшинг мөн адил тэг байлгана (ОТ-10-СЗ-PRC-0005-г үзнэ үү).	Машин хэрэглэдэг бүх хүмүүс	Бүртгэлийг хянаж үзэх
TMP 28	Замын аюулгүй байдал	Оролцогч талуудын оролцоо	Замын аюулгүй байдал, замын хөдөлгөөний талаар мэдлэг олгох хөтөлбөрийг нутгийн ард иргэдтэй хамтран хэрэгжүүлэх болно. Уг хөтөлбөрийг ОТ-ийн хамгийн их ашиглагддаг чиглэлд хэрэгжүүлнэ (Нутгийн ард иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, хамгаалалтын менежментийн төлөвлөгөөг үзнэ үү).	ОТ БХНГ-ийн хэлтэс	Замын аюулгүй байдлын хөтөлбөрийн хэрэгжилт
TMP 29	Замын аюулгүй байдал	Оролцогч талуудын оролцоо	ОТ нь Гашуун-Сухайтын замыг ашиглаж буй олон нийтэд хурдны хязгаарлалт тавьдаг болох явдлыг батлуулах, хэрэгжүүлэх ажлыг дэмжих үүднээс гол оролцогч талуудыг татан оролцуулах болно.	ОТ БХНГ-ийн хэлтэс	Замын аюулгүй байдлын хөтөлбөрийн хэрэгжилт
TMP 30	Замын аюулгүй байдал	Оролцогч талуудын оролцоо	ОТ нь зам ашиглаж буй хүмүүс аваарын үед эсвэл ядаргаагаа түр тайлахаас бусад тохиолдолд замын хажууд машинаа зогсоохгүй байхыг дэмжих ажилд гол оролцогч талуудыг татан оруулах болно.	ОТ БХНГ-ийн хэлтэс	Замын аюулгүй байдлын хөтөлбөрийн хэрэгжилт

<b>Тээврийн удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-СЗ-PLN-0002-М	Хувилбар: 1.1

## 6. ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУВААРЬ

### 6.1 Удирдлагын төлөвлөгөөний хяналт шинэчлэл

Уг удирдлагын төлөвлөгөөг хоёр жил тутамд нэг удаа эсвэл үйл ажиллагааны болон байгаль орчны нөхцлөөс хамааран илүү ойр ойрхон хянаж үзэх болно.

Төлөвлөгөөг хянаж үзэх ажлыг ОТ-ийн ЭАБ-ны асуудал хариуцсан Ерөнхий менежер хариуцах болно.

Хэрэв ажлын журамд ноцтой өөрчлөлт оруулах шаардлагатай байвал (ОТ-ийн ЭАБ менежментийн системд буй “Өөрчлөлтийн удирдлагын журам”-д заасны дагуу) уг удирдлагын төлөвлөгөөг “шаардлагатай тохиолдол” бүрт шинэчилж болно.

ОТ-ийн бүх ажилтан тус удирдлагын төлөвлөгөөний хамгийн сүүлийн хувилбарыг үзэж танилцах боломжтой байлгах үүднээс төлөвлөгөөний хянаж өөрчилсөн хувилбарыг ОТ-ийн портал дээр байрлуулах болно.

### 6.2 Хэрэгжилтийн гол үзүүлэлтүүд

Уг удирдлагын төлөвлөгөөнд тодорхойлсон менежментийн удирдлага 2013 оны 1-р сарын 1—ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлнэ.

Оролцогч ба сонирхогч талуудыг оролцуулах Төлөвлөгөө (ОТ-05-PLN-0001) болон Нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, хамгаалалтын менежментийн төлөвлөгөө (ОТ-10-PLN-0001)-д тодорхойлсончлон нутгийн иргэдийг оролцуулсан үйл ажиллагаанууд тогтмол үндсэн дээр явагдах болно.

Гэрээт гүйцэтгэгч нарын хэрэгжүүлэлт тус удирдлагын төлөвлөгөөнд тодорхойлсны дагуу хийгдэх болно. Аль нэг гэрээт гүйцэтгэгчид хамааралтай хэрэгжилтийн шаардлагуудыг тухайн гэрээт гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тодорхойлон зааж өгөх болно.

## 7. МОНИТОРИНГ

### 7.1 Мониторингийн шаардлагуудын тойм

Үйл ажиллагааны үе шатанд төслийн стандартуудын (“4-р хэсэг: Төслийн стандартууд”-г үзнэ үү) биелэлтийг үнэлэх зорилгоор хэрэгжүүлэх мониторингийн арга хэмжээнүүдийг энэ хэсэгт тодорхойлсон болно.

Мониторингийн ажлын үр дүнд төслийн стандартуудыг биелүүлээгүй болох нь тогтоогдвол эдгээрийг шалгаж, авах шаардлагатай залруулах арга хэмжээг тодорхойлох болно (“Элемент 14: ОТ ЭАБ МС-ийн “Шаардлага биелүүлээгүй хэрэг зөрчил, авах арга хэмжээний менежмент”-г үзнэ үү).

### 7.2 Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд

Доор харуулсан хүснэгтэнд гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд болон холбогдох мониторингийн гол арга хэмжээнүүдийг дүгнэсэн. Эдгээрийг тус удирдлагын төлөвлөгөөний ахиц болон үр дүнтэй байдлыг үнэлэхэд ашиглаж болно.

Тээврийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-С3-PLN-0002-М	Хувилбар: 1.1

**Хүснэгт 4: Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд, мониторингийн арга хэмжээ – Тээврийн менежмент**

ID	ГГҮ	Зорилт	Мониторингийн арга хэмжээ
TMP-KPI 01	БОМТ-д тодорхойлсон хор нөлөөг бууруулах арга хэмжээний хэрэгжилтийг хангаагүй зөрчлүүд	Бууруулах ба бүртгэгдсэн зөрчлийн тоог тууштай багасгах	Хүснэгт 3-ийн “нягтлах арга зам” гэсэн баганыг үзнэ үү
TMP-KPI 02	Хурд хэтрүүлсэн эсвэл аюултай байдлаар машин жолоодож байсан нь тогтоогдсон жолоочийн тоо	Тэг болгож бууруулах	Жолоочийн хурд хэтрүүлэлт болон аюулгүй ажиллагаатай холбоотой хэрэг зөрчлийн талаарх мэдээг хянаж үзэх
TMP-KPI 03	Дараахь үр дагавар бүхий машины ослын тоо: <ul style="list-style-type: none"> <li>• Хүний эрүүл мэнд, амь насанд хохирол учруулсан</li> <li>• Асгаралт (карго эсвэл түлш)</li> <li>• Ан амьтан мөргөсөн</li> </ul>	Тэг болгож бууруулах	Хэрэг зөрчлийн талаарх бүртгэлийн дүн шинжилгээ
TMP-KPI 04	Нутгийн иргэдийн гаргасан тээвэрлэттэй холбоотой гомдлын тоо	Тэг болгож бууруулах Түргэн шуурхай шийдвэрлэх	Санал гомдлын мэдээллийн сан (БХНГ-ийн хэлтсээр дамжуулан хийгдэх)

**7.3 Мониторингийн гол үйл ажиллагаанууд**

Мониторингийн гол үйл ажиллагаанууд нь Рио Тинтогийн “С3 Тээврийн хэрэгсэл ба түүнийг жолоодох стандарт (ОТ-10-С3-STD-0003-Е-С3)”-ийн хэрэгжилтийг хангахад чиглэгдэнэ.

Мониторингийн гол арга хэмжээнүүдийг дор тодорхойлж харуулав.



**Тээврийн удирдлагын төлөвлөгөө**

Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-С3-PLN-0001-М	Хувилбар: 1.1
---	---	------------------

**Хүснэгт 5: Мониторингийн гол арга хэмжээнүүд**

ID	Сэдэв /Хэсгүүд	Аргачлал	Мөчлөг	Байршил
TMPm1	Хурдны хязгаар	Хурдны хязгаарыг GPS-ийн машин хянах системийг ашиглан хянах болно. Уг системийг ОТ-ийн бүх машинд суурилуулах болно. Шаардлагатай бөгөөд хэрэгжүүлэх боломжтой тохиолдолд уг системийг гэрээт гүйцэтгэгчдийн тээврийн хэрэгсэлд мөн адил суурилуулах болно. Хурд хэтрүүлсэн жолооч нарт сахилгын арга хэмжээ авах болно.	Тасралтгүй хянах	Тээврийн хэрэгслийн бүх байршил
TMPm2	Ан амьтантай мөргөлдөх тохиолдол	ОТ-ийн бүх жолооч ан амьтан, тэр дундаа мал, том хөхтөн амьтан, том шувуу зэрэгтэй мөргөлдсөн бүх тохиолдлыг ОТ-ийн Байгаль орчны хэлтэст мэдээлэх шаардлагатай.	Өдөр тутам	Haulage routes
TMPm3	Жолоочийн чадвар	ОТ-ийн Уурхайн талбай дахь замын хөдөлгөөний удирдлагын төлөвлөгөөнд (ОТ-10-С3-PRC-0003-г үзнэ үү) тодорхойлсончлон ОТ-ийн бүх жолооч жолоочийн сургалтын наад захын шаардлагыг хангасан байх болно. ОТ-ийн бүх жолооч Монгол улсын хүчинтэй жолооны үнэмлэхтэй байх ёстой. Мөн ОТ-ийн зохих жолооны сургалтанд бүрэн хамрагдаж, Рио Тинтогийн “С3 Тээврийн хэрэгсэл ба түүнийг жолоодох стандарт (ОТ-10-С3-STD-0003-Е-С3)”-д заасанчлан байгууллагын зохих дотоод зөвшөөрлийг авсан байх ёстой.	Бүртгэл хөтөлж, мэдээг тогтмол шинэчилж байх	Бүх жолооч
TMPm3	Гэрээт гүйцэтгэгчийн удирдлага	Тээврийн удирдлагын төлөвлөгөөтэй холбогдуулан гэрээт гүйцэтгэгчдийн гүйцэтгэлийг үнэлэх зорилгоор ОТ нь хяналт шалгалт, аудитын хөтөлбөр боловсруулж гаргана. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>Ажлын гэрээ байгуулахын өмнө тухайн гүйцэтгэгч уг төлөвлөгөөний шаардлагуудыг хангах чадвартай эсэхийг хянаж үзэх</li> <li>Гэрээт гүйцэтгэгчийн “Онцгой байдлын үед хариу арга хэмжээ</li> </ul>	Гэрээт гүйцэтгэгчийг анхлан томилохын өмнө нэг удаа, дараа нь жил бүр. Гэрээт гүйцэтгэгчийн хэсэг хугацаанд үзүүлсэн гүйцэтгэлийг харгалзан үзээд энэхүү давтамжийг өөрчлөн тохируулж болно.	Гүйцэтгэгчийн депо

ОЮУ ТОЛГОЙ ХХК

**Тээврийн удирдлагын төлөвлөгөө**

Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-СЗ-ПЛН-0001-М	Хувилбар: 1.1
--	---	------------------

ID	Сэдэв /Хэсгүүд	Аргачлал	Мөчлөг	Байршил
		<p>авах журам” (тэр дундаа жолоочийн зүгээс авах арга хэмжээ)</p> <ul style="list-style-type: none"> <li>• Жолоочийн чадварын шалгалт</li> <li>• Тээврийн хэрэгслийн төхөөрөмж, засвар үйлчилгээний бүртгэл</li> <li>• Жолоочийн хамрагдсан сургалтын талаарх мэдээ</li> </ul>		
TMPm4	Хяналт шалгалт	ОТ-ийн Байгаль орчны хэлтсээс зөөвөрлөх чиглэлийн дагуу, ялангуяа хүн ам оршин суудаг газар гэх мэт эмзэг байршлуудад үүсч буй тоосны түвшин тогтоох үзлэг, шалгалтыг явуулна.	Замын барилга эсвэл зам сайжруулалтын ажлын дараа ба/эсвэл гомдол гаргасан тохиолдолд	Зөөвөрлөх үндсэн чиглэлүүд
TMPm5	Нутгийн иргэдэд үзүүлэх нөлөө	ОТ нь зөөвөрлөх чиглэлийн дагуу оршин суудаг нутгийн ард иргэдтэй хамтран төслийн замын хөдөлгөөний улмаас үүсч буй нөлөөллийн цар хүрээг тогтоох тал дээр үргэлжлүүлэн ажиллана.	Байнга	Төслийн зөөвөрлөх маршрутын дагуу эсвэл түүнд ойр байрладаг суурин газрууд

Тээврийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-СЗ-PLN-0002-М	Хувилбар: 1.1

## 8. СУРГАЛТ

### 8.1 Тойм

ОТ-ийн бүх жолооч Монгол улсын хүчинтэй жолооны үнэмлэхтэй, мөн ОТ-ийн зохих сургалтанд бүрэн хамрагдаж, Рио Тинтогийн “СЗ Тээврийн хэрэгсэл ба түүнийг жолоодох стандарт (ОТ-10-СЗ-STD-0003-Е-СЗ)”-д заасан зохих дотоод зөвшөөрлийг авсан байх ёстой.

### 8.2 Танилцуулга сургалт

Рио Тинтогийн “СЗ Тээврийн хэрэгсэл ба түүнийг жолоодох стандарт (ОТ-10-СЗ-STD-0003-Е-СЗ)”-тай холбогдуулан явуулах шаардлагатай ямар нэг тодорхой сургалт байхгүй.

### 8.3 Ажил үүрэгт тусгайлан зориулсан сургалт

Ажил үүрэгт тусгайлан зориулсан сургалтын шаардлагууд, мөн Рио Тинтогийн “СЗ Тээврийн хэрэгсэл ба түүнийг жолоодох стандарт (ОТ-10-СЗ-STD-0003-Е-СЗ)”-ын наад захын шаардлагуудыг ОТ-ийн “Уурхайн талбай дахь замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө (ОТ-10-СЗ-PRC-0005)”-д дараахь байдлаар тодорхойлсон байгаа.

Уурхайн талбайд машин жолоодоход тавигдах наад захын шаардлагууд:

- Хүчинтэй жолооны үнэмлэхтэй байх;
- ОТ-ийн ЭМААБО болон Ерөнхий танилцуулах сургалтанд хамрагдсан байх;
- Цооногийн жолоочийн зөвшөөрөлтэй хүмүүсийн хувьд цооногийн зөвшөөрлийн үнэлгээ (жил тутмын).

Машин жолоодоход тавигдах тусгай шаардлагуудыг “Хөнгөн машин жолоодох журам (ОТ-10-СЗ-PRC-0003)” болон “Хүнд машин механизм ажиллуулах журам (ОТ-10-СЗ-PRC-0002)”-д заасан болно.

## 9. АУДИТ БА ТАЙЛАН

### 9.1 Дотоод аудит

Ажлын талбайн харгалзагч/даамлууд эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны чиглэлийн өргөн хүрээний асуудлуудыг хамарсан үзлэг, шалгалтыг өдөр тутам явуулна. ЭМААБО-ны хэлтэс Хяналт шалгалтын хуудсыг ашиглан тогтмол шалгалтыг нэмж явуулна.

Эдгээр шалгалтын явцад тодорхойлогдсон бүх тохиолдлыг Тохиолдлын удирдлагын систем (Элемент 14) рүү мэдээлнэ.

Шаардлагын биелэлтийг “Гүйцэтгэлийн үнэлгээ, аудит (Элемент 16)”-ийн дагуу жил тутам явуулдаг дотоод аудитын хөтөлбөрөөр дамжуулан хянах болно. Энэхүү хяналт шалгалт нь ЭМААБО-ны удирдлагын систем (үүнд БОННУ болон удирдлагын төлөвлөгөөнүүд багтана)-ийн шаардлагыг өргөн хүрээнд биелүүлэх, мөн биелэлтийг хангахад чиглэгдэнэ.

БОНУТ-ийн хүрээнд заасны дагуу эдгээр шалгалтын явцад илэрсэн бүх тохиолдол, үл биелэлтийг ОТ-ийн ЭМААБО-ны удирдлагын системийн шаардлагуудад нийцүүлэн мэдээлэх болно.

<b>Тээврийн удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-С3-PLN-0002-М	Хувилбар: 1.1

### 9.2 Гадаад аудит

Уг төлөвлөгөөг дагаж мөрдөхөд Рио Тинтогийн “ЭМААБО Бизнесийн стандарт шаардлагуудын биелэлтийг хянах хөтөлбөр”-ийн хүрээнд, мөн төслийн зээлдүүлэгчид тогтмол үнэлгээ хийх нөхцөл тавигдана.

### 9.3 Бүртгэл хөтлөлт

Аудит, хяналт шалгалт, тохиолдлуудын бүртгэлийг 8-р хэсэг “Баримт бичгүүд ба тэдгээрийн хяналт”, 15-р хэсэг “Мэдээлэл, бүртгэлийн удирдлага”-д заасны дагуу хөтлөх болно.

“Дотоод, гадаад аудитын үр дүн, холбогдох арга хэмжээ”, мөн “Хэрэг зөрчлүүд, холбогдох шалгалт ба арга хэмжээ”-г бүртгэхдээ Рио Тинтогийн бизнесийн шийдлийг ашиглана.

## 10. БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТ

Файлын нэр	ОТ-10-С3-PLN-М-Тээврийн удирдлагын төлөвлөгөө
Тодорхойлолт	Үйл ажиллагааны шатны тээврийн удирдлагын төлөвлөгөө
Зохиогчид	Айвен Велла, ОТ Үйл ажиллагаа эрхэлсэн ерөнхий захирал
Үүсгэсэн огноо	2013.09.01
Баталсан	ОТ Гүйцэтгэх хороо
Баталсан огноо	2013.09.01
Бүртгэлийн дугаарын өөрчлөлт	#

Эрсдлийн зэрэглэл	Үнэлгээний огноо	Эрсдэл тооцоологч	Хянаж үзэх хуваарь	Дараагийн хяналтын огноо
Дунд	2013.09.01	Айвен Велла	2 жил тутам	2015.09.01

Хувилбар	Дахин хянасан огноо	Зохиогчид	Баталсан	Хяналтын талаарх тэмдэглэл
1.0	2013.09.01	Айвен Велла, ОТ Үйл ажиллагаа эрхэлсэн ерөнхий захирал	ОТ Гүйцэтгэх хороо	Баримт бичгийг баталсан.
1.1	2013.11.23		ОТ Гүйцэтгэх хороо	Холбогдох материалуудын дугаарыг зассан, баримт бичгийн хяналтын хэсгийг бөглөсөн.